

**УВС АЙМАГ
“ИХ БАРИЛГА УВС” ХУВЬЦААТ КОМПАНИ**

2026 оны 04 сарын 27 өдөр

Дугаар 01

Улаангом

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2025 оны 04 дүгээр сарын 27

Цаг: 14:00 (орон нутгийн цагаар)

Байршил: Компанийн хурлын өрөө

ИРЦ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 14:15 минутад компанийн хурлын өрөөнд эхэллээ. Тооллогын комиссын дарга Б.Болормаа хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн ирцийг 81%-тай байгааг танилцуулснаар хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлыг эхлүүлээ. Хуралд дараах хувьцаа эзэмшигчид оролцов (81% ирц):

1. А.Баатар-92453ш
2. А.Сумъяа-79417ш
3. Н.Амитан-51835ш
4. А.Дарьсүрэн-75000ш
5. А.Алгаа-22008ш
6. Б.Баатаржав-636ш

ТУЗ-ийн дарга А.Сумъяа хурлын дэгийг танилцуулж, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулав.

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн нэрийн зөрчлийг арилгаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХК-д бүртгэлтэй "Ихбарилга" ХК болгож өөрчлөх, үүнтэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт оруулах
3. Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг батлах
4. Бусад

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1

Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

А.Сумьяа: Өнөөдрийн хэлэлцэх 1-р асуудал болох "Компанийн 2025 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг" ерөнхий менежер Б.Гантуяа болон нябо Б.Болормаа нар танилцуулна.

А.Алгаа: Цүнхэг амралтын газрыг 2026 оны бизнес план дээр цүнхийг ер нь хэдэн хувийн ашгийн маржинтай байхаар төлөвлөж байгаа бол тэр тооцооллыг хармаар байна.

Ерөнхий менежер Б.Гантуяа: А.Алгаа хувьцаа эзэмшигчийн асуултын дагуу өнгөрсөн онд бид нар 24 сая 300 мянгын ашигтай ажилласан байна. Энэ 2026 онд бид нар 73 сая төгрөгийн ашигтай буюу өнгөрсөн жилийн орлогыг ерөнхийдөө 30% өсгөх төлөвлөгөөг тавьсан байгаа.

А.Алгаа: Орлогыг 30% өсгөхөд ашиг нь 73 сая болох юм уу тэ? Тийм. Тэгэхээр нөгөө нэг ашгийн маржин чинь нэмэгдэж байгаа гэсэн үг. Энэ 2025 оны борлуулалт болох 107 сая төгрөгийн орлого чинь 30% нэмэгдээд 140 орчим сая төгрөгний борлуулалттай ажиллах нь байна.

А.Сумьяа: Санхүүгийн тайланг ерөнхий нягтлан бодогч Б.Болормаа танилцуулна.

ШИЙДВЭР 1

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг **хангалттай** гэж батласугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2

Компанийн нэрийн зөрчлийг арилгаж "Ихбарилга" ХК болгож өөрчлөх, дүрэмд өөрчлөлт оруулах

А.Сумьяа: Хэлэлцэх асуудлын 2 дугаарт: Компанийн нэрийн зөрчлийг арилгаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж ХХК-д бүртгэлтэй "Ихбарилга" ХК болгож өөрчлөх, үүнтэй холбоотойгоор дүрэмд өөрчлөлт оруулах.

А.Алгаа: Энэ асуудал дээр бид нар нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай гэж үзэж байна.

А.Сумьяа: Энэ удаагийн хурлаар нэрний зөрчлийг арилгах ажлыг хийх тухай ТУЗ болон ГЗ-д үүрэг болгох тогтоол гарах боломжтой байна. УБХ, Архивийн Ерөнхий газраас лавлах, нэрний давхцал байгаа эсэх давхцаж байгаа бол он дарааллын хувьд аль нь түрүүлж авсан гэх мэт тодруулах ажлууд хийгдэхээр байна. Компанийн нэрийн

зөрчил үүсээд байгаа нөхцлийг тодруулах, Монгол Улсын ерөнхий архивын газраар шүүх шаардлагатай бичиг баримтны лавлагаа авах, мэдээлэл цуглуулах зэрэг үүрэг даалгаварыг ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт үүрэг өгөх, Компанийн нэр өөрчлөхтэй холбоотой бичиг баримтны бүрдэл бэлэн болоход ээлжит бус хурлаар дахин хуралдаж шийдвэрлэх саналыг дэмжих эсэх дээр санал хураая.

ШИЙДВЭР 2

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар Компанийн нэрийн зөрчлийг арилгахтай холбогдуулан Өмч хувьчлалын үеийн баримт бичиг, компани үүсгэн байгуулагдах үеийн бүртгэлийг орон нутаг болон Монгол Улсын ерөнхий архивын газраас шүүж үзэх, шаардлагатай бичиг баримтны лавлагаа авах, мэдээлэл цуглуулах үүрэг даалгаварыг ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нарт үүрэг болгосугай.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3

Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг батлах

А.Сумьяа: Хэлэлцэх асуудлын 3 дугаарт: Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын дүнг батлах гэсэн асуудал байна аа.

А.Алгаа: Хөрөнгө оруулалтын задаргааг харахад зарим нэг ажлууд тусгагдаагүй харагдаж байна.

А.Сумьяа: Миний хувьд хөрөнгө оруулалтын дүнг нэмэгдүүлэх саналтай байна.

А.Алгаа: Миний хувьд ижил саналтай байна. Цүнхэгийг амралтын хувьд бид нар ихээхэн хөрөнгө оруулалтыг тийшээ хаяад энийг бид нар ийм бүрэн хэмжээний ашиг орлого сайтай аялал жуулчлалын том цэг болно гэж харж байгаа. Өнгөрсөн жил бид нар ерөөсөө хийгдэх нийт ажлынхаа 40%-өөс 50%-ийг л хийгээд орхичихсон. Тийм болохоор хөрөнгө оруулалт зайлшгүй нэмж хийгдэх шаардлагатай гэж үзэж байна.

Б.Баатаржав: Тийм ээ, дэмжиж байна.

А.Сумьяа: Хэлэлцэх асуудлын 3-д байгаа Цүнхэг төсөлд шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг 500,000,000.0 төгрөгөөр батлахыг дэмжиж байна уу?

ШИЙДВЭР 3

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар Цүнхэг төсөлд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг **500,000,000.0 (таван зуун сая) төгрөгөөр баталсугай.**

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалыг тогтоох тухай

Хувьцаа эзэмшигч А.Сумьяа: ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын урамшууллыг улиралд 400,000 (дөрвөн зуун мянга) төгрөг байх, хурлын цагийн хөлсийг нэг цагт 8,000 (найман мянга) төгрөгөөр батлах санал оруулж байна.

Хувьцаа эзэмшигч А.Баатар : Ер нь бол хангалттай гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч А.Алгаа: Тиймээ. Цаашдаа компаний үйл ажиллагааг сайжруулах, зөвлөн чиглүүлэх ажлууд хийгдэхийн тулд ТУЗ маань улирал тутамд буюу жилд 4 удаа хуралдахаар байгаа. Миний хувьд хурлын даргын саналыг дэмжиж байна.

ШИЙДВЭР 4

Хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын урамшууллыг улиралд 400 мянган төгрөг байхаар, хурлын цагийн хөлсийг нэг цагийн 8000 төгрөгөөр тус тус баталсугай.

Хурал даргалагч: А.Сумьяа

Нарийн бичгийн дарга:

